



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Ширээний теннисний тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33,5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах Ширээний теннисний тэмцээнийг 2017 оны 06 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд “Оч” спорт клубын зааланд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 2.482.000 /Хоёр сая дөрвөн зуун наян хоёр мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэг/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500075

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Ширээний теннисний тэмцээнийг зохион
байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 36 x 10.000 төг = 360.000 төг 36 x 8.000 төг = 288.000 төг 36 x 5.000 төг = 180.000 төг	828.000
2.	Шүүгчдийн ажлын зардал: /16 хүн x 2 өдөр x 20.000 төг/	640.000
3.	Өргөмжлөл:	100.000
4.	Медаль:	864.000
5.	Анонс/цом	50.000
ДҮН:		2.482.000

Боловсруулсан
Хянасан

С.Саранцэцэг
О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн
7/28 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Ширээний теннисний тэмцээний
шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|-----------------------|--------------|
| 1. Ерөнхий шүүгч | С.Галбадрах |
| 2. Нарийн бичиг шүүгч | Н.Нэргүй |
| 3. Шүүгч | А.Даваасүрэн |
| 4. Шүүгч | Р.Батбаяр |
| 5. Шүүгч | Я.Баастхүү |
| 6. Шүүгч | Ж.Болд |
| 7. Шүүгч | Т.Бат-Эрдэнэ |
| 8. Шүүгч | Н.Буянхишиг |
| 9. Шүүгч | М.Золзаяа |
| 10. Шүүгч | Э.Эрдэнэбаяр |
| 11. Шүүгч | Т.Ууганбаяр |
| 12. Шүүгч | Б.Хулангоо |
| 13. Шүүгч | Э.Гүнзориг |
| 14. Шүүгч | Б.Төгөлдөр |
| 15. Шүүгч | П.Энхмандах |
| 16. Шүүгч | Б.Шагдар |